



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/58

Номгон

Жаргалант сумын цэцэрлэгийн
тоглоомын талбай байгуулах ажлын
барьцаа хөрөнгө чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоол “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.9.1, 2.9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний 729, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 30-ны 2/166, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 2024/24 дугаар дүгнэлтийн дагуу Жаргалант сумын цэцэрлэгийн тоглоомын талбай байгуулах ажлын чанарын баталгаа болох 6,243,153 (Зургаан сая хоёр зуун дөчин гурван мянга нэг зуун тавин гурван) төгрөгийг чөлөөлөхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т үүрэг зөвшөөрсүгэй.

2. Барилга байгууламжийн гадна, дотор засал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны зэргийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, Жаргалант сумын Засаг дарга (Б.Саранцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ



